



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

ЖАРГАЛТХААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Л.ЭНХТУЯА ТАНАА

№ \_\_\_\_\_  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


**Үүрэг, хариуцлага**

Жаргалтхаан сумын Цэцэрлэг нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

630574

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

116

## ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Төгмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
хараах хаягаар харилцана уу:

### Аудитын тайлан

АБ-ын Тэргүүлэх аудитор  
тас: 70562112  
Хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
тас: 70562147  
Хаяг: otuya\_099@yahoo.com

Аудитор: Ц.Хатанболд  
тас: 70562147  
Хаяг:

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АБ-ын хаяг  
Хайршил: Хэнтий аймаг Хэрлэн  
Ум 3-р баг АЗДТГ-ын байр  
Хаяг хуудас:  
Khentii@audit.gov.mn

2018 оны 03 дугаар сар

# Байгуулга

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/170/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, мэтлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн газрын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Ц.Хатанболд эрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 19-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 2 дугаар сарын 22-ноос 2018 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 28-нд байгууллагын мөрддөг гардуулав.

## Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн тухай хууль, Болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр баруун, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт оруулж байна.

## Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин дэмжих, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол

119  
"Хэрэгжүүлэхэд оршино" гэсэн бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн эрхлэгч Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын төрийн сангаар дамжуулан олгож байна.

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн ерөнхийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын мэдээлэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын 9 хяналтын горим, нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

### Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Хэнтий аймгийн төрийн сангийн харилцах хансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 226,9 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 226,7 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 0,2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

### Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн. Төсөв, мч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай шийдвэрийг шилэн дансны нэгдсэн системд айршуулаагүй байна.

### Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн үрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 9 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг шалгахад тогтоосон норм хэмжээг хэтрүүлэн зарцуулсан, ур чадварын нэмэгдлийг тодорхой шалгуур үзүүлэлтгүйгээр ажилтануудад олгосон, батлагдсан орон тоог 1-ээр хэтрүүлэн ажилласан, бараа материалын үлдэгдэлийг тооцоо бодож баталгаажуулаагүй зэрэг зөрчил илэрсэн нь санхүүгийн тайлангийн оршин байгаа, орон тоо ба хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай гүйцэтгэл, гэрээний гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг нэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, зооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

### Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад ураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг шалгахад тогтоосон норм хэмжээнээс 147,8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Цалингийн зардлыг анхан шатны баримтаас шалгахад 823.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тодорхой шалгуур үзүүлэлтгүйгээр ажилтануудад олгосон, батлагдсан орон тоог 1-ээр хэтрүүлэн ажилласан байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

121

**Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын**

**талаарх тайлбар:**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 5 алдаа, бараа материалын үлдэгдлийн тооцоог бодож баталгаажуулаагүй зөрчил нь материаллаг бус санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй тул залруулга хийгдээгүй.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 36,5 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрсэн хүүхдийн хоолны нормыг хэтрүүлэн зарцуулсан 0,1 сая төгрөг, бараа материалын дансны үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй 21,8 сая төгрөг, урсгалын нэмэгдлийг тодорхой шалгуур үзүүлэлтгүйгээр ажилтануудад олгосон, батлагдсан зарим тоог 1-ээр хэтрүүлэн ажилласан зэрэг 823,9 мянган төгрөг, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 13,7 сая төгрөгийн алдаа зөрчил нийт 36,5 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Монголиан бизнес рейтинг аудит" ХХК аудит хийж 2 зөвлөмж өгсөнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

**Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:**

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн үйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, жил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.


Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 13 хуудас, хавсралтууд 4 хуудас, байгууллагын тайлан 1 хуудсыг тус тус хавсаргав.

**Аудитын тайланг**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Ц.ХАТАНБОЛД

Огноо: 2018.03.03

**Хянасан:**

**Бэлтгэсэн:**



# ЖАРГАЛТХААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Нягтлан бодох бүртгэлийн талаар .....	3
Асуудал 2	
Төсвийн зарцуулалтын талаар .....	4
Асуудал 3	
Дотоод хяналтын талаар.....	5

### Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар ирүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад ирүүлж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйлчилгээ, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Жаргалтхаан сумын цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг өөрчлөх аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд илрүүлж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал үзэхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

**Төрүүлэлт:**

1. Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 21,8 сая төгрөгийн үлдэгдэл бүхий бараа материалын үлдэгдлийг тооцоо бодож баталгаажуулаагүй байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Зөвлөмж:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн дагуу эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулж тооцоо бодож тооллогын үр дүнг баталгаажуулж байх

**Эрсдэл:**

- НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх

**Төсвийн захирагчийн хариу:**

**Ирүүлэлт:**

1. Цалингийн зардлыг анхан шатны баримтаас шалгахад үр дүнгийн тайланд 823.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тодорхой шалгуур үзүүлэлтгүйгээр ажилтануудад олгосон, батлагдсан орон тоог 1-ээр хэтрүүлэн ажилласан байна. Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байдал, оршин байгаа батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.
2. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг шалгахад тогтоосон норм хэмжээнээс 147,8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрсэн. Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байдал, оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

**Зөвлөмж:**

1. Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 362/112/183 тоот тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллах
2. Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 2-д "Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 (нэг мянга зургаан зуун тавин) төгрөгөөр, 24 цагаар ажилладаг цэцэрлэг, сувиллын болон тусгай цэцэрлэгт 2400 (хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр тус тус тогтоосугай" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

**Эрсдэл:**

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх  
Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

**Төсвийн захирагчийн хариу:**

**Тэргүүлэлт:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 13.7 сая төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Зөвлөмж:**

3. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.5, 6.4.8 дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол үнэн зөв мэдээлж байх

**Эрсдэл:**

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх

**Төсвийн захирагчийн хариу:**


**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Ц.ХАТАНБОЛД

**БЭЛТГЭСЭН:**

Огноо: 2018-03-03 44297  
СНОА0046 9074382